

Монгол Улсын Засгийн газар
ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
(2017-2021)

Агуулга

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1 Тулгамдаж буй асуудал, өнөөгийн нөхцөл байдал
- 1.2 Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага
- 1.3 Хөтөлбөрийн зарчим

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Хөтөлбөрийн зорилго
- 2.2 Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- 4.1 Үр дүн
- 4.2 Шалгуур үзүүлэлт

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ

- 5.1. Санхүүжилт
- 5.2. Шаардагдах хөрөнгө

ЗУРГАА. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 6.1. Удирдлага, зохион байгуулалт
- 6.2. Хяналт шинжилгээ, үнэлгээ

Хавсралт 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хавсралт 2. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн хяналтын хүснэгт, шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгө, урьдчилсан төсөв

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал

Монгол Улсын Засгийн газар жендэрийн тэгш байдлыг хангах, хүний эрх, ялангуяа эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалахын төлөө Жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөр (2003-2015) боловсруулж, батлан хэрэгжүүлсэн 12 жилийн хугацаанд *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004)*, *Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль/ЖЭТБХТХууль/ (2011)*, *Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2011)*, *Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)* зэрэг хэд хэдэн чухал хуулийг УИХ-аар батлуулан мөрдүүлснээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчныг үндсэнд нь бүрдүүлсэн юм.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр нь 2011 онд ЖЭТБХТХууль батлах хүртэл үндэсний жендэрийн бодлогыг тодорхойлох гол баримт бичиг байсан бөгөөд уг хуулийг боловсруулан батлуулах суурь болсон юм. 2013 онд Монгол Улсын Засгийн газраас ЖЭТБХТХуулийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны стратеги (2013-2016) батлан хэрэгжүүлж байна. Энэхүү стратеги нь агуулга, зарчмын хувьд Үндэсний хөтөлбөрийг дэмжин, үндсэн чиглэлүүдийг хуулийн заалтуудад нийцүүлэн нарийвчилж, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаатай илүүтэй уялдуулсан байна. Тиймээс 2002 оноос хойш үндэсний болон орон нутгийн түвшинд өрнөсөн жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаа нь бүхэлдээ энэ хоёр баримт бичгийн хэрэгжилтийг хангахад чиглэж ирсэн.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон ЖЭТБХТХуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги хэрэгжих хугацаанд эрх зүй, бодлогын орчин хөгжсөнөөс гадна хэрэгжүүлэх тогтолцоо, чадавхийг бүрдүүлэх чиглэлээр дараах чухал ажлууд хийгджээ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайд ахалсан Жендэрийн Үндэсний Хороо/ЖҮХ/ 2005 онд байгуулагдаж, жендэрийн тэгш байдлын асуудлаар байгуулагдсан хороо, зөвлөлийн тоо хоёр дахин нэмэгдэж, бүх төрийн захиргааны төв байгууллагад ЖҮХ-ны салбар хороо, аймаг, нийслэл, дүүрэгтсалбар зөвлөл албан ёсоор ажиллаж байна. ЖҮХ-ны дэргэд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, Жендэр консорциум байгуулагдан мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Түүнчлэн үндэсний хэмжээнд анх удаа жендэрийн сургагч багш нарыг бэлтгэн, салбар зөвлөл, хорооны гишүүдийг чадавхижуулах чиглэлээр хамтран ажиллажээ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улсын төсвөөс олгох санхүүжилт жил дутам нэмэгдсэн төдийгүй зарим аймагт орон нутгийн төсвөөс гэр бүлийн хөгжил дэх жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд тодорхой санхүүжилт хуваарилж байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголт хандлага дээшилж, хүчирхийллийн хохирогчид үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвүүд нийслэл, зарим аймагт байгуулагдаж, хамтарсан багууд гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох чиглэлээр ажиллаж хэвшээд байна.
- Төрийн албан хаагчдын шалгалтад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд 40 гаруй асуултыг багтаагаад байна.

- Нийт 3 салбарт жендэрийн стратеги батлан хэрэгжүүлж байна. Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2013), Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагуудад хэрэгжих жендэрийн стратеги (2015), мөн Хууль зүйн салбар, төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого (2016) батлагдсан байна.
- Завхан, Баянхонгор, Ховд аймгууд жендэрийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж эхэлсэн ба бусад салбар, орон нутгууд ч энэ чиглэлээр санаачлага гарган ажиллаж байна.
- Нийгэм, хүн ам зүйн хүйсээр ангилсан статистик тоон мэдээлэл болон төрийн албаны түвшинд хүйсийн тэнцвэрт байдлын талаарх бүртгэл, тайланг тогтмол гаргаж хэвшиж байна.
- Хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхийн өмнө жендэрийн үнэлгээ хийх журмыг ХЗЯ-наас гарган баталснаар жендэрийн үнэлгээ шинжилгээ төрийн бодлого, үйл ажиллагаанд нэвтрэх суурь тавигдлаа. Мөн Сангийн болон Хууль зүйн салбарын баримт бичгүүдэд жендэрийн шинжилгээ хийсэн нь жендэрийн аудитыг хөгжүүлэх эхлэл боллоо.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх үндсэн зарчмуудыг зөвшилцөн, нэвтрүүлэх ажил эхэлж, улсын болон орон нутгийн төсвийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, энэ чиглэлийн мэдлэг мэдээллийг түгээх чиглэлээр ЖҮХ-ны Ажлын алба, Сангийн яам, Удирдлагын академи үр дүнтэй хамтран ажиллаж, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хэрэгслүүдийг боловсруулж байна.
- Монгол Улсын Засгийн газраас олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж ирсэн. Тус улсад 2011 онд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг (АОХН)-ийн “Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх олон улсын чуулга уулзалт, 2012 онд “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох нь” сэдэвт Азийн бүсийн бага хурал, 2013 онд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7 дахь удаагийн бага хурлын хүрээнд зохиогдсон Эмэгтэйчүүдийн чуулган, Зүүн бүсийн Азийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалтыг зохион байгуулсан зэрэг нь жендэрийн ба эмэгтэйчүүдийн асуудалд олон нийтийн, ялангуяа бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулахад нааштай нөлөөлж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн үр дүн жил бүрийн Засгийн газрын мониторинг үнэлгээгээр дунджаар 80.0 гаруй хувийн биелэлттэй үнэлэгдэж иржээ. Тус хөтөлбөрийг анх боловсруулах үед буюу 15 жилийн өмнө жендэрийн тэгш байдлын зорилт, үйл ажиллагааг өргөн цар хүрээ, алсын хараатай эхлэн тодорхойлж чадсан нь өнөөгийн тулгамдсан асуудал, дэвшүүлж буй зорилтуудтай нийцэж буй байдлаас харагддаг юм. ЖЭТБХТХуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, төлөвлөгөөний 6 тэргүүлэх зорилтын хүрээнд 4 жилийн хугацаанд хийхээр төлөвлөсөн 62 үйл ажиллагаа нийт дүнгээрээ 60.1 хувь биелсэн байна.

Сүүлийн жилүүдэд дундаж наслалт уртассан, эхийн эндэгдэл буурсан, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, боловсролд хамрагдалт сайжирсан ахицтай үзүүлэлтүүд гарсан нь Жендэрийн хөгжлийн индексийг тодорхойлоход эергээр нөлөөлж байна. Дэлхийн эдийн засгийн форумас эрхлэн гаргадаг эдийн засаг, улс төр, боловсрол, эрүүл мэндийн салбарын шалгуур үзүүлэлт бүхий Жендэрийн зөрүүтэй байдлын тайланд дурьдсанаар манай улсын индекс 2006 онд 0.682 байсан бол бага зэргийн

ахиц гарган 2013 онд 0.720 гэсэн индекс¹ээр 136 орноос 33 дугаар байранд орсон байна. Харин НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс гаргадаг Жендэрийн хөгжлийн индекс нь 2005 онд 0.401 байснаас 2012 онд 0.328 болж дээшилжээ. Жендэрийн зөрүүтэй байдлын гол асуудал болон тавигдаж байсан хөвгүүдийн сургууль завсардалт буурч, их, дээд сургуульд суралцагчдын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэн, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд хандах Засгийн газар, олон нийтийн хандлага сайжирч байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны идэвх сайжирч, УИХ, нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогдон ажиллахаар нэрээ дэвшүүлж буй эмэгтэйчүүдийн тоо сүүлийн жилд нэмэгдсэн байна.

Ийнхүү эрх зүйн орчин боловсронгуй болж, жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд ахиц дэвшил гарч байгаа боловч эдийн засаг, соёлын хүрээнд гарч буй зарим өөрчлөлт жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж, шийдвэрлэх асуудал шинээр гарч ирсээр байна.

Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт оршсоор байна. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци/ЭЯГБХУТК/-ийн хэрэгжилтийн Монгол Улсын Засгийн газрын найм, есдүгээр тайланд өгсөн дүгнэлтээс үзэхэд эмэгтэй, эрэгтэй хүний нийгэм, гэр бүлдээ гүйцэтгэх үүргийн талаарх хэвшмэл ойлголт гүн оршсоор, эмэгтэйчүүдийн боловсрол, мэргэжлийн сонголтод нөлөөлж, улс төр, нийгмийн амьдралд оролцоог нь хязгаарлаж, хөдөлмөрийн зах зээлд, гэр бүлийн амьдралд тэгш бус байдлыг үүсгэж байна. Хөдөөгийн, ялангуяа алслагдсан орон нутгийн эмэгтэй, эрэгтэйчүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт бүрдээгүй, эмэгтэйчүүдийн хүний эрхийн талаарх ойлголт бага байгааг мөн дээрх тайланд өгсөн дүгнэлтэд онцолсон байна.

Энэчлэн бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэн, хэвшмэл ойлголтыг халах чиглэлээр бодитой ахиц дэвшил харагдахгүй байна. Энэ асуудлыг эрхлэх гол түншлэгчид болох боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх байгууллага, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагууд дор бүрнээ явцуу хүрээнд, хязгаарлагдмал нөөцөөр ажиллаж, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал боловсролын салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд нэгтгэгдээгүй байгаа нь үүнд нөлөөлж байна.

Хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, түүний дотор нөхөн үржихүйн насны залуу эмэгтэйчүүдийг, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байх, ахимаг насны эмэгтэйчүүдийг эрт тэтгэвэрт гаргах үзэгдлүүд түгээмэл байна.

Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд зориулсан санхүүгийн эх үүсвэр тодорхой биш, санхүүжилт тогтвортой биш байна. Хэрэгжүүлсэн бүх бодлого, хөтөлбөр хангалттай санхүүжилт, хүний нөөц байхгүйн улмаас төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Иймд тус улсын хувьд бодлого, хөтөлбөрт жендэрийн үзэл баримтлалыг тусгах, улсын болон орон нутгийн төсвийг жендэр мэдрэмжтэй төсөвлөх асуудал гол тулгамдсан асуудал болж байна.

¹Жендэрийн зөрүүтэй байдлын индекс: 0.00 нь тэгш бус байдал, 1.00 тэгш байдал

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн болон олон улсын донор байгууллагуудын зүгээс үндэсний түвшинд хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсээр ирсэн боловч санхүүжилтийн цар хүрээ жил тутам хумигдан, тодорхой хэдэн асуудалд чиглэж байна. Мөн хувийн секторын зүгээс дэмжлэг үзүүлэх хүсэл эрмэлзэл, сэдэл байхгүй байна. Бээжингийн үйл ажиллагааны хөтөлбөр нь улс орны Засгийн газруудад эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад хангалттай нөөц хуваарилахыг уриалж, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх талууд хувь нэмрээ оруулах хэрэгтэйг анхааруулсан байдаг.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, стратеги төлөвлөгөөг үндэсний хэмжээнд гардан хэрэгжүүлэгч ЖҮХ-ны статус доошлон, ажлын албаны орон тоо хоёр дахин буурснаар салбар хоорондын зохицуулалт хийх чадамж суларсан нь түүний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн. Салбар, орон нутгийн хүйсээр ангилсан мэдээллийн сан, түүний ашиглалт сул, жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэхэд хангалтгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хүргэх чиглэлээр салбар дундын зохицуулалт бий болох эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч энэ нь жендэрт суурилсан хүчирхийллийн бусад хэлбэрүүдтэй тэмцэх ажлын хувьд хангалтгүй байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх гомдлыг хүлээж авах механизм байгаа ч хянан шийдвэрлэх арга зам тодорхойгүй хэвээр, байгууллагуудын дотоод журамд тусгах ажил эхлэлийн шатандаа байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах шинэ үндэсний хөтөлбөрийг Тогтвортой Хөгжлийн үзэл баримтлалд суурилан, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (2015)-ийн хүрээнд, Хүн амын талаас төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулахдаа дээр дурьдсан нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг харгалзан үзэх, урт хугацааны жендэрийн бодлого төлөвлөлтийн суурийг тавихуйц оновчтой зорилт, үйл ажиллагааг санхүүгийн эх үүсвэрийн хамт төлөвлөх хэрэгцээ тулгарч байна.

1.2 Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар Засгийн газар жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж, арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах үүрэгтэй.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээний дүгнэлтээр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, энэ нь нэг талаас үндэсний хэмжээнд хяналт тавих тогтолцооны чадавхи сул, тухайн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, хүний нөөц, санхүүгийн боломж хязгаарлагдмал байгаатай холбоотой, нөгөө талаас хүн амын жендэрийн боловсрол хангалтгүй байгаа явдал гэж үзжээ.

Түүнчлэн өнөөгийн нөхцөлд дэлхий дахинаа болон Монгол Улсын хэмжээнд ойрын 15 жилийн хугацаанд эх дэлхийгээ болон улс орноо хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр

зорилтуудыг шинээр дэвшүүлэн тавиад байна. Монгол Улсын Их Хурлаас 2016 онд “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийг, 2015 онд Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025), 2016 онд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/-ийг тус тус баталсан. Эдгээр нь НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны 70/1 тогтоолоор баталсан “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”-ийн жендэрийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах учиртай.

Энэхүү хөтөлбөрт тусгаснаар дэлхий дахинд ядуурлын эсрэг, оролцоог хангасан, хүртээмжит ногоон хөгжлийн хандлагыг бодлого, төлөвлөлтөд тусгах нь эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн тулгамдсан асуудлыг цогцоор нь шийдэх арга зам гэж үзэж байна. Ногоон хөгжлийн бодлого нь хүн төвтэй зарчмыг эн тэргүүнд баримтлан, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн хүрээнд иргэдийн оролцоог дэмжихийг, тогтвортой хөгжлийн засаглалыг төлөвшүүлэх болон төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх асуудалтай эн чацуу гэж үздэг.

Ядуурлыг бууруулах стратеги нь жендэрийн дүн шинжилгээг эдийн засаг, нийгмийн бодлого, хөтөлбөрүүдэд цогц хэлбэрээр тусгасан байхыг шаарддаг. Түүнчлэн ядуурлын талаарх мэдээллийг нас хүйсээр нь төрөлжүүлж, эдийн засгийн бүхий л үйл ажиллагаа болон эмэгтэйчүүдийн цалинтай ба цалин хөлсгүй хөдөлмөр, тэдний зүгээс үндэсний эдийн засагт оруулж буй хувь нэмрийг харагдахуйцаар таниулах статистик мэдээлэл цуглуулахыг чухалчлан үздэг.

Иймд дээрх бодлого, хөтөлбөрт тусгасан зорилго, зорилтуудад хүрэх дараагийн шатны арга хэмжээг тодорхойлох Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах шаардлага гарч байна.

1.3 Хөтөлбөрийн зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- а) Жендэрийн тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эмэгтэй, эрэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийн баталгааг хангах нөхцлийг бүрдүүлж, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэгдэнэ.
- б) Эмэгтэй, эрэгтэй хүн нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шимээс тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцлөөр хангагдана.
- в) Хөтөлбөр нь НҮБ-ын Ерөнхий ассамблейн “2030 хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, тэдгээрийн зорилтуудтай нягт уялдаатай байна.
- г) Төрийн бодлого төлөвлөлт, үнэлгээнд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай хэрэгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг салбар, орон нутгийн онцлог, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагатай нягт уялдуулна.
- д) Жендэрийн тэгш байдлын талаарх мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгоно.
- е) Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бүхий л санаачлагыг урамшуулан дэмжинэ.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг хөгжүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээгээр ЖЭТБХТХуулийн хэрэгжилтийг дэмжиж, нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг сайжруулахад оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

Зорилт 1. Тогтвортой хөгжил дэх жендэрийн тэгш оролцоог дэмжиж, эрэгтэй, эмэгтэй хүний хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 1-д хүрэх үр дүн:

- *Хөдөлмөрийн зах зээл дэх ялгааварлан гадуурхалт буурч хөдөлмөрийн насны эмэгтэй, эрэгтэй хүний зохистой хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэнэ.*
- *Эрэгтэй, эмэгтэй хүнд тэгш хүртээмжтэй ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх үндэсний түншлэл, хамтын ажиллагаа хөгжинө.*
- *Эрэгтэй, эмэгтэй хүн, жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хөгжинө.*
- *Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй бага орлоготой өрх толгойлсон эцэг/эхийн амьжиргааны түвшин дээшилнэ.*

Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг бүх түвшинд хөгжүүлнэ.

Зорилт 2-т хүрэх үр дүн:

- *Хүйсээр ангилсан нийгэм, эдийн засгийн мэдээлэл бүрдүүлэх, түүнд жендэрийн дүн шинжилгээ хийх болон бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн дүн шинжилгээг ашиглах чадавхи сайжирна.*
- *Салбар, орон нутаг, байгууллагын түвшинд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлт хийх арга зүйг нэвтрүүлнэ.*

Зорилт 3. Бүх нийтийн жендэрийн боловсролыг дэмжсэн, эрэгтэй эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн соён гэгээрүүлэх, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлнэ.

Зорилт 3-т хүрэх үр дүн:

- *Бүх нийтийн жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага сайжирна.*
- *Гэр бүлийн гишүүдийн жендэрийн тэгш байдлын ойлголт, хандлага болон үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх эцэг, эхийн үүрэг, хариуцлага сайжирч, зөв, эрүүл амьдралын хэвшил төлөвшинө.*

- *Эмэгтэй, эрэгтэй хүний үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажилд хэвлэл мэдээллийн байгууллага, залуус манлайлан оролцох чадавхи бүрдэнэ.*
- *Нийгэм, хамт олон, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгүүдийн оролцоо нэмэгдэнэ.*

Зорилт 4. Жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоог бүх түвшинд боловсронгуй болгож, чадавхи, механизмыг сайжруулна.

Зорилт 4-т хүрэх үр дүн:

- *Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны салбар хоорондын уялдаа, зохицуулалт бүх түвшинд сайжирна.*
- *Жендэрийн тэгш байдлыг хангах нийгмийн түншлэлийн хүрээ өргөжнө.*

Зорилт 5. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, нийгмийн үйлчилгээг цогцоор нь хөгжүүлэх, ГБХТТ хуулийн хэрэгжилтийг хангах, нотолгоонд суурилсан ажлын арга зүйг боловсронгуй болгох

Зорилт 5-д хүрэх үр дүн:

- Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх механизм сайжирна.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих, урьдчилан сэргийлэх олон нийтийн ойлголт, хандлага нэмэгдэнэ.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээ сайжирна.

Зорилт 6. Улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.

Зорилт 6-д хүрэх үр дүн:

- Эмэгтэйчүүдийн улс төр, шийдвэр гаргах түвшин дэх оролцоо нэмэгдэнэ.
- Улс төрийн намын тогтолцоо, бодлого, үйл ажиллагааны жендэрийн мэдрэмж сайжирна.
- Салбар, орон нутаг, байгууллагын бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад эмэгтэй, эрэгтэй хүний тэгш оролцоо нэмэгдэнэ..

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

ЗОРИЛТ 1-ИЙН ХҮРЭЭНД:

Үйл ажиллагааны чиглэл 1.1. Эрэгтэй, эмэгтэй хүний зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжин хөдөлмөрийн зах зээл дэх ялгаварлан гадуурхлыг бууруулах

1.1.1 Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхлын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах, хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтийг гарган нэвтрүүлэх

1.1.2 Иргэнийг ажилд авахад ажилласан жил, нас, хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гаргасан зөрчилд ногдуулах хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах

1.1.3 Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй, гэр бүлд ээлтэй болгоход чиглэсэн сургалтын модулийг боловсруулан ҮЭ-ийн байгууллагатай хамтран нэвтрүүлэх

1.1.4 Малчин, тариаланч өрхийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээ (зээл, татвар, техник, технологи, хүний нөөцийн хөгжлийн зэрэг)-нд жендэрийн дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих

Үйл ажиллагааны чиглэл 1.2. Ногоон эдийн засгийн хөгжилд жендэрийн тэгш оролцоог дэмжих

1.2.1 Эрэгтэй, эмэгтэй хүн, нийгмийн бүлгийн хэрэгцээнд нийцсэн, тэгш хүртээмжтэй ногоон ажлын байр бий болгох сайн туршлагыг судлан нэгтгэж, хэвлэн түгээх

1.2.2 Төсвийн санхүүжилтээр хэрэгжих үйл ажиллагаанд “Ядуурлын эсрэг, тэгш оролцоот, хүртээмжит ногоон хөгжлийн хандлага”-ыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан түгээх

1.2.3 Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй бага орлоготой өрх толгойлсон эцэг/эхийн амьжиргааг дээшлүүлэх жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах

Үйл ажиллагааны чиглэл 1.3. Эмэгтэй эрэгтэй хүн, жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх

1.3.1 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинет (хүний нөөц, техник тоног төхөөрөмж бүхий)-ийг бүх аймаг, дүүрэгт ажиллуулах

1.3.2 Орон нутагт улирлын ажил эрхлэгч, ашигт малтмалыг гар аргаар олборлогч, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэй, эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн эрсдлээс хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийх

1.3.3 Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй зохион байгуулах чадавхийг сайжруулах цуврал сургалт хийх

1.3.4 Эрүүл мэнд, нөхөн үржихүйн хичээлийн агуулгыг насны онцлогт тохируулан боловсруулж, ЕБС-д албан сургалтаар, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт тус тус оруулах

ЗОРИЛТ 2-ЫН ХҮРЭЭНД:

Үйл ажиллагааны чиглэл 2.1. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг бүх түвшинд хөгжүүлнэ.

2.1.1 Жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах тусгай программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, үүрэг хүлээгчдэд түгээх

2.1.2 Жендэрийн суурь мэдээллийг багтаасан, ашиглахад хялбар статистик мэдээллийн товхимлыг жил бүр тогтмол гаргах

2.1.3 Жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж, үүрэг хүлээгчдэд түгээх

Үйл ажиллагааны чиглэл 2.2. Улс орны жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, үр дүнг түгээн, бодлого төлөвлөлтөд оновчтой тусгуулах

2.2.1 Улс орны жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах

2.2.2 Улс орны жендэрийн дүн шинжилгээний үр дүнгээр үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний бага хурлыг тогтмол зохион байгуулах, түүний сэдэв, агуулгыг сурталчлан таниулах, мэдээллийг хэвлэн түгээх, үүрэг хүлээгчдэд хүргүүлэх

2.2.3 Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа эрэгтэй, эмэгтэй тэтгэвэр авагчдын тэтгэврийн зөрүүтэй байдалд судалгаа хийж, холбогдох санал боловсруулах

2.2.4 Иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг бодлого, хууль тогтоомжид тусгуулах чиглэлээр ажиллах

2.2.5 ЖТБХҮХөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

Үйл ажиллагааны чиглэл 2.3. Эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлыг судлан, шийдвэрлэх арга хэмжээ авах

2.3.1 Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх оролцоо, үнэлэмж хандлага болон гэр бүлийн хүрээнд тулгамдаж буй асуудалд суурь судалгаа хийх

2.3.2 Малчин залуучуудын жендэрийн байдалд дүн шинжилгээ хийх

2.3.3 Судалгааны үр дүнгээр үндэсний хэмжээнд бодлогын хэлэлцүүлэг хийж, зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах

Үйл ажиллагааны чиглэл 2.4. Салбар, орон нутаг, байгууллагын жендэрийн бодлого төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих

2.4.1 Салбаруудын жендэрийн нэгдсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх

2.4.2 Орон нутгийн Жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах, салбар хороодоос сум, хороотой хамтран ажиллах нэгдсэн удирдамж гаргах

2.4.3 ЖҮХ-ны аймаг, нийслэл, дүүргийн салбар хороодод орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх

2.4.4 Салбар, орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд жендэрийн аудит хийж, зөвлөмжийг хэрэгжүүлэх

2.4.5 Бүх шатны Засаг даргатай байгуулах Үр дүнгийн гэрээнд Жендэрийн хууль, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах

Үйл ажиллагааны чиглэл 2.5. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хэрэгслийг бүх шатны бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээнд нэвтрүүлэх

2.5.1 Төсөвлөгчдийг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн он-лайн сургалтад хамруулах

2.5.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийх гарын авлага, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийх, төсвийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх аргачлал боловсруулах

2.5.3 Олон улсын байгууллага төсөл хөтөлбөрөөс жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр оруулсан хувь нэмэр, зарцуулсан санхүүжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэх

ЗОРИЛТ 3-ЫН ХҮРЭЭНД:

Үйл ажиллагааны чиглэл 3.1. Бүх нийтийн жендэрийн боловсролыг дэмжсэн, эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн гэгээрэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлнэ.

3.1.1 Багш бэлтгэх бүх сургуулийн сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, түүнд жендэрийн агуулгын шалгуур үзүүлэлт боловсруулж тусгах

3.1.2 МСҮТ, СӨБС, ЕБС-ын багш нарын давтан сургалтын хөтөлбөрт жендэрийн агуулгыг тусгаж, туршин, үр дүнг үнэлэх

3.1.3 Жендэрийн хуульд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэг, бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцагчийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх

3.1.4 Жендэрийн хуульд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэй оюутны тоог нэмэгдүүлэх

3.1.5 Бүх шатны боловсролын хөтөлбөр, сурах бичигт жендэрийн агуулгыг тусгах ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх

3.1.6 Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгах

3.1.7 Жендэрийн мэдрэмжтэй заах арга зүйн удирдамж гаргаж ЕБС, их дээд сургуулийн багш нарыг чадавхижуулах

Үйл ажиллагааны чиглэл 3.2. Гэр бүлийн хүрээнд жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгахад чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол явуулах

3.2.1 Гэр бүлийн гишүүд дэвшилтэт уламжлалд суурилсан, бие биенээ хайрлах, хүндлэх ёс суртахуун, хүнлэг чанарыг эрхэмлэх, зөв, эрүүл амьдралын зан үйлд суралцах, хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах

3.2.2 Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах, хэвшүүлэх, үр хүүхэддээ хөдөлмөрч, шударга ёс суртахуун төлөвшүүлэх талаар болон шилдэг гэр бүлийн үлгэр жишээг сурталчлан дэлгэрүүлэх, урамшуулах

3.2.3 Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг захиалгаар бэлтгэх болон эрүүл мэнд- сэтгэл зүй-эрх зүйн зөвөлгөө өгөх чадавхийг бүх аймаг, дүүрэгт нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 3.3. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн бодлого, түүний хэрэгжилтэд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, сэтгүүлчийн жендэрийн мэдрэмжийг нэмэгдүүлэх

3.3.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт /ЮНЕСКО-Монгол/-ийг түгээх, хэрэгжилтийг хангуулах, жендэрийн тэгш байдлын бодлого, ёс зүйн код баталж, баримтлах

3.3.2. Хэвлэл мэдээллийн байгууллага (телевиз, сайт)-ын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх /Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт /ЮНЕСКО-Монгол/-ийн дагуу/

3.3.3. Сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн агуулгыг нэвтрүүлэн, сэтгүүлчдэд үе шаттай сургалт хийх

3.3.4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад туслахуйц шинэлэг дүр төрхийг бүрдүүлэх компани ажил зохион байгуулах

3.3.5. Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийн цагтай болгох

Үйл ажиллагааны чиглэл 3.4. Жендэрийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголтыг арилгахад эрэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэх, залуусын манлайллыг дэмжих, сайн туршлагаудыг бий болгох

3.4.1. Эрэгтэйчүүд/ялангуяа 18-35 насны/-ийн жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтад хамруулах, олон улсын аян, төсөл хөтөлбөрт татан оролцуулах

3.4.2. Манлайлагч, олны танил, эсхүл зөв дадалд шилжсэн эрэгтэйчүүдийн амжилт ололтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх

ЗОРИЛТ 4-ИЙН ХҮРЭЭНД:

Үйл ажиллагааны чиглэл 4.1. Жендэрийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх

4.1.1 Жендэрийн үндэсний хорооны бүтэц, тогтолцоог Жендэрийн хуульд нийцүүлэн, хэрэгжилтийг хангуулах

4.1.2 Жендэрийн үндэсний шинэ хөтөлбөрийн хүрээнд Жендэрийн шинжээчдийн бүлэг, Жендэрийн консорциум, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин, тогтворжуулах

4.1.3 Жендэрийн салбар хороо, зөвлөлийн жишиг дүрмийг гаргаж, хяналт тавих, дүрмийн дагуу жендэрийн асуудал хариуцсан орон тооны ажилтан ажиллуулах эхлэлийг тавих

4.1.4 ЖҮХ, ЖҮШБ, ЖК, ХМЗ, салбар хороо, зөвлөл, тэдгээрийн ажилтныг чадавхижуулах, ажлын үр дүнгээр жил бүр шалгаруулж, шагнаж урамшуулах

4.1.5 ЖҮХ-ны тогтмол мэдээллийн цагийг бий болгох

4.1.6 Жендэрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, сургалт, сурталчилгаа тогтмол явуулах, үндэсний сургагч багш, салбарын шинжээчийг бэлтгэх

4.1.7 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийх

Үйл ажиллагааны чиглэл 4.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчийн чадавхийг дээшлүүлж, манлайллыг бий болгох

4.2.1 Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, ойлголт хандлагыг сайжруулах, манлайллыг бий болгох чиглэлээр сургах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

4.2.2 Залуучууд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан албан хаагч, нийгмийн ажилтанд зориулсан жендэрийн гарын авлага боловсруулж, сургалтад хамруулах

4.2.3 Удирдах ажилтанд зориулсан жендэрийн он-лайн сургалтын модуль боловсруулан туршиж, нэвтрүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 4.3. Жендэрийн тэгш байдлыг хангах нийгмийн түншлэлийг хөгжүүлэх

4.3.1 Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтэй хамтран шилдэг аж ахуйн нэгжийн шалгаруулалтад үнэлгээ хийж, жендэрийн үзүүлэлтийг тусгах

4.3.2 Хувийн хэвшил, ажил олгогч, бизнесийн байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй хамтран жендэрийн тэгш байдлыг дэмжих санхүү эдийн засаг, бизнес, техник технологи, инновацийн хөшүүргүүдийг тодорхойлох, тэдгээрийг урамшуулах

4.3.3 Жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, ИНБ, иргэдийг сурталчлан таниулах, шагнаж урамшуулах

4.3.4 Аймаг, нийслэл, дүүргийн Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх чадавхийг орон нутгийн төрийн бус байгууллагад бий болгох.

ЗОРИЛТ 5-ЫН ХҮРЭЭНД:

Үйл ажиллагааны чиглэл 5.1 Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх механизмыг сайжруулах

5.1.1 ХЭҮК-ийн орон нутгийн ажилтан, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх асуудлаар ажиллах заавар боловсруулан, нэвтрүүлэх

5.1.2 Охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх

5.1.3 Гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт явуулах, гэр бүлийн болон сэтгэл зүйн зөвөлгөө тогтмол өгөх

Үйл ажиллагааны чиглэл 5.2. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих, урьдчилан сэргийлэх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах

5.2.1 Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл тогтмол түгээх

5.2.2 Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүний эрх, жендэрийн чиглэлийн олон улсын тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах

5.2.3 Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх статистик мэдээллийг боловсруулах программ бий болгох, олон нийтэд хүргэх, ЖҮХ-ны мэдээллийн нэгдсэн санд нэгтгэх

Үйл ажиллагааны чиглэл 5.3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах механизмыг сайжруулах

5.3.1 Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх талаар хөдөлмөрийн болон хамтын гэрээ, байгууллагын дотоод журамд тусгах тухай зөвлөмж гарган, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх

5.3.2 Аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байран дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, ажил олгогчийн зүгээс хохирогчийн гомдлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх

5.3.3 Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж/Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байр зэрэг/ийг бүх аймагт ажиллуулж, үйл ажиллагааны зардлыг төсвөөс санхүүжүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэх

5.3.4 Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгжийн стандартын хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж гаргах

5.3.5 Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг шинэчлэн, хэрэгжүүлэх.

ЗОРИЛТ 6-ГИЙН ХҮРЭЭНД:

Үйл ажиллагааны чиглэл 6.1. Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх

6.1.1 Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн аудит хийж, жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх

6.1.2 Улс төрийн намын дүрэмд улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн суудал хадгалах квотыг 35 хувиас доошгүйгээр тогтоож, хэрэгжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл 6.2. Эмэгтэйчүүдийн улс төр, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх

6.2.1 УИХ-д сонгогдсон эмэгтэй 35 хувиас доошгүй, аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон эмэгтэй 40 хувиас доошгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх

6.2.2 Төрийн өндөр албан тушаалд санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн хуульд заасан квотыг хэрэгжүүлэх

6.2.3 Эмэгтэйчүүдийг улс төр, шийдвэр гаргах түвшинд бэлтгэх, чадавхижуулах, манлайллыг бий болгох сургалт тогтмол явуулах

6.2.4 Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2017-2021 оныг хамруулан 2017-2018 онууд, 2019-2021 онуудад хоёр үе шаттайгаар үйл ажиллагааны бие даасан төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна:

4.1.1 Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллага нэмэгдсэн байна.

4.1.2 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тасаг, кабинет бүх аймаг, дүүрэгт бий болсон байна.

4.1.3 Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй бага орлоготой өрх толгойлсон эцэг/эхийн амьжиргаа дээшлүүлэх жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулсан байна.

4.1.4 Хүйсээр ангилсан статистик мэдээллийг ашиглах программ, заавар үүрэг хүлээгчдэд бүрэн нэвтэрч, товхимол жил бүр хэвлэгдэнэ.

- 4.1.5 Улс орны жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийгдэж, зөвлөмж бодлого, төлөвлөлт, төсөвлөлтөд тусгагдана.
- 4.1.6 Салбарын ба орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөө, дэд хөтөлбөр бүрэн батлагдана.
- 4.1.7 Жендэрийн аудит хийсэн салбарын ба орон нутгийн тоо нэмэгдэнэ.
- 4.1.8 Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн онлайн сургалтад бүх төсөвлөгч хамрагдсан байна.
- 4.1.9 Боловсролын салбарын бодлого, бүх шатны боловсролын хөтөлбөр, сурах бичиг жендэрийн агуулгатай болсон байна.
- 4.1.10 Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр суралцагч эрэгтэйчүүдийн тоо нэмэгдэнэ.
- 4.1.11 Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцагч эмэгтэй оюутны тоо нэмэгдэнэ.
- 4.1.12 Гэр бүл-сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ бүх түвшинд нэмэгдэнэ.
- 4.1.13 Жендэрийн бодлого, ёс зүйн код баталсан болон жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ хийсэн ХМБ-ын тоо нэмэгдэнэ.
- 4.1.14 Жендэрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, үндэсний сургагч багш, салбарын шинжээч бэлтгэгдэнэ.
- 4.1.15 Удирдах ажилтан, төрийн албан хаагчид жендэрийн сургалтад бүрэн хамрагдсан байна.
- 4.1.16 Жендэрийн тэгш байдлыг дэмжих санхүү эдийн засаг, бизнес, техник технологи, инновацийн хөшүүргийг тодорхойлсон ААН, байгууллагын тоо нэмэгдсэн байна.
- 4.1.17 Орон нутгийн төрийн бус байгууллага Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн тоо нэмэгдсэн байна.
- 4.1.18 Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж бүх аймаг, дүүрэгт ажиллаж, үйл ажиллагааны зардлыг төсвөөс бүрэн санхүүжүүлнэ.
- 4.1.19 Аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байран дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн гомдлыг шийдвэрлэх зохицуулалт бий болсон байна.
- 4.1.20 Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн аудит хийгдэж, зөвлөмж, төлөвлөгөө гарсан байна.
- 4.1.21 Улс төрийн намын дүрэмд улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн суудал хадгалах квотыг 35 хувиас доошгүйгээр тогтоосон намын тоо нэмэгдсэн байна
- 4.1.22 УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийн 35 хувиас доошгүй, аймаг, нийслэлийн ИТХ-д нэр дэвшигчийн 40 хувиас доошгүй нь эмэгтэй байхаар хуульчлагдсан байна.
- 4.1.23 Төрийн өндөр албан тушаалд санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг шинээр тогтоож, Жендэрийн хуульд заасан квот хангагдсан байна.
- 4.1.24 Нутгийн өөрөө удирдах бүх шатны байгууллагын баталсан бодлогын баримт бичигт жендэрийн үзэл баримтлал туссан байна.

4.2 Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2015 он)	Дунд хугацаанд үнэлэх түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2021 он)
1.	Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллага	Хувь	00	20 хувь	35 хувь
2.	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тасаг, кабинетийн тоо /бүх аймаг, дүүрэгт/	тоо	11	20	30

3.	Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй бага орлоготой өрх толгойлсон эцэг/эхийн амьжиргааг дээшлүүлэх жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулалт	тоо	00	1	1
4.	Хүйсээр ангилсан статистик мэдээллийг ашиглах программ, заавар	Хувь	00.0	70 хувь	100 хувь
5.	Хүйсээр ангилсан статистик мэдээллийн товхимол	Жил бүр	00.0	100 хувь	100 хувь
6.	Улс орны жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийгдсэн тоо	тоо	00.0	1	1
7.	Батлагдсан салбарын ба орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөө, дэд хөтөлбөрийн тоо	Тоо	Салбарын 3, Орон нутгийн 3	7 20	13 30
8.	Жендэрийн аудит хийсэн салбарын ба орон нутгийн тоо	Тоо	Салбарын 3, Орон нутгийн 00	7 20	13 30
9.	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн онлайн сургалтад хамрагдсан байгууллагын тоо	Тоо/хувь	22 төсөвлөгч /91 хувь	100 хувь	100 хувь
10.	Жендэрийн агуулга бүхий боловсролын салбарын бодлогын тоо	Хувь		50 хувь	100 хувь
11.	Жендэрийн агуулга бүхий боловсролын хөтөлбөр, сурах бичгийн хувь	Хувь		50 хувь	90 хувь
12.	Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр суралцагч эрэгтэйчүүдийн тоо	Тоо, хувь	18 хувь	35 хувь	50 хувь
13.	Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцагч эмэгтэй оюутны тоо	Тоо, хувь	30 хувь	40 хувь	50 хувь
14.	Гэр бүл- сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний хүртээмж	Хувь			
15.	Жендэрийн бодлого, ёс зүйн код баталсан ХМБ-ын тоо	Тоо	00	20 хувь	30 хувь
16.	Жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ хийгдсэн ХМБ-ын тоо	Тоо	2	10	20
17.	Бэлтгэгдсэн жендэрийн үндэсний сургагч багш, салбарын шинжээчийн тоо	Тоо, хувь	Үндэсний сургагч багш 25 Салбарын шинжээч 00	35 15	50 30
18.	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан хаагчийн хувь	Хувь	удирдах ажилтан төрийн албан хаагч		
19.	Жендэрийн тэгш байдлыг дэмжих санхүү эдийн засаг, бизнес, техник технологи, инновацийн хөшүүргийг тодорхойлсон ААН, байгууллагын тоо	Тоо, хувь	00	5 хувь	10 хувь
20.	Орон нутгийн төрийн бус байгууллага Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн байдал	Тоо, хувь	00.0	15/50 хувь	30/100 хувь
21.	Жендэрт суурилсан хүчирхийлэлд	Тоо	10	20	30

	өртсөн хохирогчийг хамгаалах нэгжийн тоо /бүх аймаг, дүүрэгт/				
22.	Төсвөөс санхүүжүүлж байгаа хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	Тоо	10	20	30
23.	Ажлын байран дахь бэлгийн дарамтаас сэргийлэх, хохирогчийн гомдлыг шийдвэрлэх зохицуулалттай болсон аж ахуйн нэгж, байгууллага	Хувь	00.0	10 хувь	20 хувь
24.	Улс төрийн намын бодлого, үйл ажиллагаанд хийгдсэн жендэрийн аудит, зөвлөмж, төлөвлөгөө	тоо	00	3	5
25.	Улс төрийн намын дүрэмд улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн суудал хадгалах квотыг 35 хувиас доошгүйгээр тогтоосон байдал	Тоо, хувь	Квот тогтоосон намын тоо 00 Тогтоосон квотын хувь 00	5 25 хувь	8 35 хувь
26.	УИХ-д сонгогдсон байх эмэгтэйчүүдийн квотыг 35 хувиас доошгүй байхаар хуульчилсан байдал	Хувь	00	Квотын хувь 20-аас доошгүй	Квотын хувь 35-аас доошгүй
27.	Аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон байх эмэгтэйчүүдийн квотыг 40 хувиас доошгүй байхаар хуульчилсан байдал	Хувь	00	Квотын хувь 30-аас доошгүй	Квотын хувь 40-өөс доошгүй
28.	Төрийн өндөр албан тушаалд санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн хуульд заасан квот хангагдсан байдал	Хувь		Квот хангагдсан 80 хувь	Квот хангагдсан 100 хувь
29.	Нутгийн өөрөө удирдах бүх шатны байгууллагын баталсан бодлогын баримт бичигт жендэрийн үзэл баримтлал туссан байдал	Хувь	5 хувь	50 хувь	100 хувь

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ

5.1 Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1 Улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2 Олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4 Бусад эх үүсвэр.

5.2. Шаардагдах хөрөнгө

Нийт шаардагдах хөрөнгө 19.667.0 сая төгрөг, үүнээс улс, орон нутгийн төсвөөс 11.721.0 сая төгрөг, түншлэгч олон улсын байгууллагаас 7.946.0 сая төгрөг.

ЗУРГАА. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

6.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилт, төсөв хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, үр дүнд үнэлгээ хийлгэх зэрэг чиг үүргийг Жендэрийн Үндэсний Хороо хариуцна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох бүх байгууллага, иргэдийн оролцоог хангаж, иргэний нийгмийн зүгээс тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулж, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хандивлагчдын дэмжлэгийг өргөжүүлнэ.

6.1.1 Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба дараах үүрэгтэй:

- а) Хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлах;
- б) Шаардлагатай төсөв, хөрөнгийн тооцоог хийж, холбогдох байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх;
- в) Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжих, нягт уялдаа холбоотой хамтарч ажиллах;
- г) Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, нийтэд мэдээлэх; хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг холбогдох этгээдэд тогтмол өгч байх;

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

6.1.2 ЖЭТБХТХ-ийн дагуу үүрэг хүлээгч байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага;

- а) Салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;
- б) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагаас санхүүгийн дэмжлэг авах ажлыг зохион байгуулах;
- в) Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ЖҮХАА болон холбогдох үүрэг хүлээгчтэй хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах;
- г) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж, ЖҮХАА-нд хүргүүлэх;

6.1.3 Нутгийн өөрөө удирдах байгууллага

- а) Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх жендэрийн дэд хөтөлбөрийг батлах;
- б) Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах;
- в) Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж, үр дүнг олон нийтэд мэдээлэх, гүйцэтгэлд хяналт тавих;
- г) Үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачлагыг дэмжих, урамшуулах, хамтран ажиллах;

6.1.4 Төрийн бус байгууллага

- а) Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах, иргэдийн санал, санаачлагыг идэвхжүүлэх;
- б) Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэх;

6.1.5 Аж ахуйн нэгж, байгууллага

- а) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамтын ажиллагааг өрнүүлэх;
- б) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийн дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлд оролцох;
- в) Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх;

6.1.6 Хэвлэл мэдээллийн байгууллага

- а) Жендэрийн тэгш байдал болон жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийллийг үл тэвчих мэдлэг, ойлголтыг олон нийтэд таниулах;
- б) Жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх;

6.2 Хяналт шинжилгээ, үнэлгээ

Төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагууд дараа жилийн 02 дугаар сарын 20-нд багтаан хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийн дагуу Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ.

ЖҮХАА нэгдсэн тайланг гаргана. Хөтөлбөрийн нэгдсэн тайланд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг 04 сарын 1-ний дотор Засгийн газар, Үндэсний хороонд жил бүр танилцуулна.

Жендэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-р заалтын дагуу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ ажлыг тусган хийж, хоёр жил тутамд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт танилцуулна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах шаадлагатай арга хэмжээг авах үйл ажиллагааг ЖҮХ хариуцан гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийг 2017-2021 оныг хамруулан 2017-2018 онууд, 2019-2021 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхдээ дараах үнэлгээг хийнэ. Үүнд:

1. Явцын үнэлгээг 2019 оны 6 сард
2. Төгсгөлийн үнэлгээг 2022 оны 1 сард

Жендэрийн асуудлаар мэргэшсэн судалгааны байгууллага, багаар гэрээний үндсэн дээр хөтөлбөрийн хэрэгжилтэд 2 жилд нэг удаа хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд тайланг Засгийн газарт танилцуулна.

----- оОо -----